

# МОНГОЛ ДАХЬ БИОХИМИЙН ЧАНАРЫН ГАДААД ХЯНАЛТ №6

## Хяналтанд ашиглах үзүүлэлт

Биохимийн 23 үзүүлэлт:

<b>AST</b>	Аспаргин аминотрансфераза	<b>BUN</b>	мочевин /шээг/	<b>TP</b>	Нийт уураг	<b>Fe</b>	Төмөр
<b>ALT</b>	Аланин аминотрансфераза	<b>CRE</b>	Креатинин	<b>ALB</b>	Альбумин	<b>Na</b>	Натри
<b>LDH</b>	Лактат дегидрогеназа	<b>UA</b>	Шээсний хүчил	<b>T-BIL</b>	Нийт билирубин	<b>K</b>	Кали
<b>γ-GT</b>	Гамма глутамил трансфераза	<b>GLU</b>	Глюкоз	<b>D-BIL</b>	Шууд билирубин	<b>Cl</b>	Хлор
<b>AMY</b>	Амилаза	<b>T-CHO</b>	Нийт холестерин	<b>IP</b>	Фосфор	<b>Mg</b>	Магни
<b>ALP</b>	Шүлтлэг фосфатаза	<b>TG</b>	Триглицерид	<b>Ca</b>	Кальци		

## Хяналтын ийлдэс

3 төрлийн ийлдсийг шинжилнэ:

QAP-trol ( хөлдөөсөн ийлдэс) 5 м 2 түвшингийн хяналтын ийлдэс тус бүр 2 флакон

Pool serum (Цуглуулсан ийлдэс) 5 мл 1 түвшингийн хяналтын ийлдэс 2 ширхэг

**Хяналтын ийлдсийг хүлээн авсан өдрөө шинжилнэ үү.**

Анхааруулга: Сорьцыг шинжлэх хүртэл зааврын дагуу хөргөгчинд хадгалах

## Ийлдсийг найруулах, гэсгээх арга

### **Ийлдэс 1, 2**

(1) Уг ийлдсийн тасалгааны температурт 30 минут гэсгээсний дараа 2-3 удаа сайтар холино.

(2) Ийлдсийг хэрэглэж дууссаны дараа сайтар таглан сэрүүн, харанхуй (2-8 хэм) газар хадгална.

**Анхааруулга: Хэрэглэсэн ийлдсийг хяналтын хариу гарах хүртэл хөргөгчинд хадгална уу!**

### **Ийлдэс 3**

(1) Цуглуулсан ийлдсийг тасалгааны температурт 30 минут байлгасаны дараа шинжилнэ.

## Хэмжилт хийх

Хяналтын ийлдэс бүрийг өдөр тутмын шинжилгээний сорьцын нэгэн адил шинжлэх ба үзүүлэлт бүрээр 3 удаа хэмжинэ.

## Хариуны хуудас бөглөхөд анхаарах зүйл:

(1) Ерөнхий мэдээлэл

Байгууллагын нэр, эмчийн нэр, утасны дугаар, анализаторын кодноос гадна үзүүлэлт тус бүрийн хэмжилтийн арга, төрөл, калибровка хийх арга, хэмжилт хийх хэм, урвалжийн үйлдвэрлэгч, нэгжийн код болон лавлах хэмжээг **Хуудас А** дээр бөглөнө үү (Хуудас А дахь загварыг харж бөглөнө).

(2) Хэмжилтийн хариу

Үзүүлэлт бүр дээр хяналтын ийлдсийг 3 удаа шинжлэн гарсан хариуг **Хуудас Б** дээр бөглөнө үү (Хуудас Б дахь загварыг харж бөглөнө).

(3) Үзүүлэлт тус бүрийн нэгжийг **зөвхөн СИ нэгжээр** өгнө үү.

## Хяналтын хариу илгээх хугацаа

2014 оны 11-р сарын 05- ны дотор авчрах ба хөдөө орон нутгаас бол дараах факсаар явуулна уу.

Шастины Нэрэмжит Төв Эмнэлэг, Лавлагаа Лаборатори “MEQAS” Утас: 70180718 Факс: 70180718

E-mail: info@meqas.mn

